



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 01

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Эдийн засгийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан - Дундговь аймгийн харьяат Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн Санхүү бүртгэлийн албаны Санхүүгийн дотоод хяналтын ажилтан Сэрсэнгийн Чогсомыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Гавъяат эдийн засагч” цолоор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 02

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Эрүүл мэндийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Дундговь аймгийн Тана шүдний эмнэлгийн шүдний техникч Цэдэнбалжирын Батбэхийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” -оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА



С.СҮХБААТАР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 03

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Хөнгөн хүнсний салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан Дундговь аймгийн Сайнцагаан сумын 4 дүгээр багийн ахмад настан Дамирангийн Нямдоржийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон” -оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр: Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай

ДАРГА  С.СҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 04

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Дундговь аймгийн төр, төрийн бус байгууллага, боловсрол, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, санхүү, хэвлэл мэдээлэл, шуудан үйлчилгээ, авто тээврийн салбарт олон жил, үр бүтээл, идэвх зүтгэл гарган ажилласан иргэдийн нэрсийг хавсралтаар баталж, Монгол Улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.

Хоёр. Шагналын материалыг холбогдох хууль, журам зааврын дагуу бүрдүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.Мөнгөнцоож/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24
өдрийн 04 тогтоолын хавсралт



Алтан гадас одон”-гоор:

1. Пүрэвдуламын Ганбат – Сайнцагаан сумын Эрдмийн далайцогцолбор сургуулийн ахмад настан
2. Шадавын Жалцан –Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн ахмад настан
3. Сүнрэвдоржийн Өлзийсайхан – Сайнцагаан сумын Наран багийн ахмад настан
4. Дашзэвгийн Мөнхжаргал – Говь-Угтаал сумын Ажирхай багийн ахмад настан
5. Батсуурийн Жаргал - Говь-Угтаал сумын Ажирхай багийн ахмад настан
6. Даваасүрэнгийн Сарантуяа – Дундговь аймгийн Татварын хэлтсийн ахмад настан
7. Буян-Өлзийн Сосорбурам- Хулд сумын Уул багийн ахмад настан
8. Сономын Базарсүх- Дэлгэрцогт сумын ахмад тээвэрчин
9. Падсүрэнгийн Зоригт- Дэлгэрцогт сумын ахмад тээвэрчин
10. Сэрээтэрийн Бямбаа- Сайнцагаан сумын Далай багийн ахмад настан
11. Түмэндэмбэрэл Цэцэгчимэг- Сайнцагаан сум Оюуны гэгээ ТББ-ын гүйцэтгэх захирал

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар:

1. Аюурын Лхагвасүрэн - Говь-Угтаал сумын 1 дүгээр багийн ахмад настан
2. Сугирын Нарангэрэл –Гурвансайхан сумын ахмад настан



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 05

Мандалговь

Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн
2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 е, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр (2017-2019)-ийн 2019 онд хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэж 98.9 хувь буюу “Хангалттай” гэж үнэлсүгэй.

Хоёр. Төлөвлөгөөний хэрэгжилтийг Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр хариуцсан Ажлын хэсэг, Авлигатай тэмцэх газрын цахим програмаар тайлагнан хүргүүлж, Тэргүүлэгчдээс гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 06

Мандалговь

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3 а, н заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 сарын 30-ны өдрийн 77 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-д дор дурдсан агуулга бүхий заалтыг нэмснийг нэгдүгээр хавсралтаар, “Орон нутгийн өмчийг хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

1/ 5.5 дэх заалт:

5.5. Үл хөдлөх хөрөнгө доорх газрын хамт шилжсэн тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гарсан тохиолдолд газрын гэрчилгээ, кадастрын зураг, гэрээнд өөрчлөлт оруулж, шилжүүлэн авсан хуулийн этгээд өөрийн нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлэх /гэрчилгээ гаргуулах/ арга хэмжээ авна.

Хоёр. Журамд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан энэхүү тогтоолыг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав. “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус мөрдөж ажиллахыг сум болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24
өдрийн 06 тогтоолын нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ДАНСНААС ХАСАХ, ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, бэлтгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг баримтлана.
- 1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 1.3. Сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийг /мотоциклоос бусад/ энэ журмын дагуу баримт бүрдүүлэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийн хамт Орон нутгийн өмчийн газарт уламжилж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 1.4. Сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээд мотоцикл болон бусад хөдлөх хөрөнгийг олж авах, акталж данснаас хасах, худалдах, шилжүүлэх тухай саналаа энэ журмын дагуу баримт бүрдүүлэн сумын ИТХ-д уламжилж шийдвэрлүүлнэ.
- 1.5. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бэлтгэх, шилжүүлэх, худалдах, актлах талаар ирүүлсэн саналыг хянан үзээд энэ журамд заасны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулан шийдвэрлүүлж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.
- 1.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү журмыг баримтлана.
- 1.7. Хөрөнгө худалдах, хувьчлах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

Хоёр. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүрдүүлэх материал

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухай харилцаанд хамааралтай баримт материалыг бүрдүүлж цаасаар болон файлаар ирүүлнэ. Үүнд:

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авахдаа:

2.2.1. худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр

2.2.2. эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд үнийн санал

2.2.3. худалдан авах хөрөнгийн өнгөт фото зураг

2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө акталж данснаас хасах болон худалдахдаа:

2.3.1. хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт

2.3.2. холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт

2.3.3. ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл

2.3.4. байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт дүгнэлт

2.3.5. үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох байгууллагын дүгнэлт

2.3.6. үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй буу, галт зэвсгийн талаар Цагдаагийн байгууллагын албан бичиг, дүгнэлт

2.3.7. түүх, соёлын дурсгалт зүйлсийн талаарх аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал

2.3.8. Актлах хөрөнгийн мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.3.9. Актлах хөрөнгийн өнгөт фото зураг

2.3.10. бусад шаардлагатай баримт материал

2.4. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү журмын 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ

2.4.1. Үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрын эзэмших /ашиглах/ эрхийн санхүүгийн тайланд бүртгэсэн үнэлгээ, гэрчилгээ, газар эзэмшүүлэх /ашиглуулах/ гэрээ, кадастрын зургийн хуулбар,

2.4.2. үл хөдлөх хөрөнгөнд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын /зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт/ болон ашиглалтын талаарх мэдээлэл

2.4.3. барилгын паспортын хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын зураг /план/, гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад баримт бичиг,

2.4.4. худалдах үл хөдлөх хөрөнгөнд эрх бүхий байгууллагаар хийлгэсэн үнэлгээний тайлан

2.4.5 үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрыг хэрхэн шийдвэрлэх талаар гаргасан санал

2.4.6. Актлах барилгын мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.5. тээврийн хэрэгслийн хувьд энэхүү журмын 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ

2.5.1. тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техник ашиглалтын дэвтэр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээний хуулбар

2.5.2. техникийн үзүүлэлт, 3 талаас авсан өнгөт фото зураг

2.5.3 төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн мэдээлэл, холбогдох баримт

2.5.4. ашиглалтын сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардлын дүн

2.5.5. Актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.6. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэхүү журмын 2.3, 2.5-д зааснаас гадна дараах баримт мэдээллийг ирүүлнэ

2.6.1. механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар

2.6.2. барилга байгууламжид суурилагдсан бол энэ тухай мэдээлэл

2.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө балансаас балансад шилжүүлэхдээ:

2.7.1 Балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт

2.7.2 Шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл /хавсралт маягтын дагуу/

2.7.3 Шилжүүлэх хөрөнгийн фото

Гурав. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах

3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах болон хуульд заасан бусад үндэслэлээр олж авна.

3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн байгууллагын төсөвт зардалаа уялдуулан, өмч хамгаалах Байнгын зөвлөлтэй хамтран өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган 2 дугаар сарын 15-ны дотор Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

3.3. Эд хөрөнгийн захиалга, жагсаалтанд тоо хэмжээ, үнийн дүн /үнэ/, хүчин чадал, техникийн үзүүлэлт, бусад шаардлагатай тайлбар тодорхойлолтыг тусгана.

3.4. Орон нутгийн өмчийн газар жагсаалтыг нягтлан шалгаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулан үндсэн хөрөнгө бэлтгэх шийдвэр гаргуулна.

3.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар эд хөрөнгө худалдаж авах тохиолдолд санхүүгийн эх үүсвэрээ эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсний дараа Орон нутгийн өмчийн газар саналаа ирүүлж болно.

3.6. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах , шилжүүлэх, актлах асуудал хамтад нь тавьж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгийг бүртгэх

4.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, энэ журмын 4.2-т заасны дагуу зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд нь тухайн хөрөнгийг ашиглалтанд хүлээн авсан Улсын комисс /ажлын хэсэг/-ын акт, санхүүжилт баталгаажуулсан эрх бүхий байгууллагын тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журам, заавар стандартын дагуу үнэлж бүртгэнэ.

4.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь улсын төсвийн хөрөнгө оруулал, орон нутгийн хөгжлийн сан, банкны зээл, хандив, тусламж бэлэглэл, өр төлбөрт тооцон үл хөдлөх хөрөнгө болон бусад үндсэн хөрөнгө олж авбал тухай бүр Орон нутгийн өмчийн газарт мэдэгдэж, уг хөрөнгийг холбогдох хууль тогтоол, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна.

4.3. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламжийн ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд Орон нутгийн өмчийн газар орж, хүлээн авсан актыг үндэслэн тухайн барилга объектын санхүүгийн тайланд тусгах үнэ өртгийг тооцон, эзэмшигч байгууллагыг тогтоож, санхүүгийн тайлан балансад бүртгүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

Тав. Эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

5.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар орон нутгийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашиглагдаагүй эд хөрөнгийг шилжүүлэх бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, энэхүү журмын 2.7-д заасны дагуу бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

5.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, баланс тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана.

5.3. Үл хөдлөх хөрөнгө болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.4. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг хөрөнгө шилжүүлж авсан байгууллага хариуцна.

5.5. Үл хөдлөх хөрөнгө доорх газрын хамт шилжсэн тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гарсан тохиолдолд газрын гэрчилгээ, кадастрын зураг, гэрээнд өөрчлөлт оруулж, шилжүүлэн авсан хуулийн этгээд өөрийн нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлэх /гэрчилгээ гаргуулах/ арга хэмжээ авна.

Зургаа. Эд хөрөнгийг акталж, данснаас хасах

6.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэхүү журмын 2.3 – 2.6-д заасан баримт материалын хамт Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

6.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр данснаас хасна:

6.2.1. элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон

6.2.2. ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд

6.2.3. техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон

6.2.4. балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон

6.2.5. ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон

6.3. Орон нутгийн өмчийн газар, сумын өмч хамгаалах зөвлөл данснаас хасах саналыг хүлээн авч, эд хөрөнгийг газар дээр нь нягтлан шалгаад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэр гарах хүртэл эд хөрөнгийг байгууллагын удирдлагад хариуцуулж, энэ тухай протокол үйлдэн гарын үсэг зуралцана.

6.4. Аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид нь эд хөрөнгийг акталж данснаас хасахдаа дараах хэлбэрээр шийдвэрлэнэ:

6.4.1. эд хөрөнгийг худалдах

6.4.2. орон нутгийн өмчит бусад хуулийн этгээдэд шилжүүлэх

6.4.3. сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах

6.4.4. шууд устгах

6.4.5. барилга байгууламжийн хувьд тухайн газрыг цаашид ашиглах зориулалтын талаар чиглэл өгөх

6.4.6. газар дээрх болон доорх барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх

6.5. Үл хөдлөх хөрөнгөд их засвар хийгдэхэд засвар хийгдсэнээс гарсан хуучин материалыг Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор сум болон байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлрөөр үнэлгээ хийлгэн эргэлтийн хөрөнгөд бүртгэх эсхүл худалдан борлуулж, худалдсанаас олох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 100 хувь төлөвлүүлнэ.

**Долоо. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө
олж авах, бэлтгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас
хасах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах**

7.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бэлтгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг Орон нутгийн өмчийн газар болон сум, байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ.

7.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бэлтгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг заасан хугацаанд холбогдох материалын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх үүрэг хүлээнэ.

7.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөнд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана.

Найм. Бусад

8.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлана.

8.2. Орон нутгийн өмчит байгууллагын үндсэн хөрөнгө акталж худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 100 хувь төвлөрүүлнэ.

8.3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгөтэй холбоотой гарсан зардал, хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

8.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 06 тогтоолын хоёрдугаар хавсралт

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛОН
СУМЫН ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөл /цаашид өмч хамгаалах зөвлөл/-ийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд баримтлах зарчим, эрх, үүргийг тодорхойлоход оршино.
- 1.2. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь орон тооны бус, байнгын үйл ажиллагаатай байна.
- 1.3. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагаанд хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтлана.
- 1.4. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын тухай багц хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас баталсан тогтоол, шийдвэр, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.5. Энэхүү журмыг орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөл үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээд гэдэгт төсөвт байгууллага, түүний салбар нэгж, сан, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг тус тус ойлгоно.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу өмч хамгаалах зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал эсхүл түүний үүрэг гүйцэтгэдэг менежерээр ахлуулж ерөнхий нягтлан бодогч, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэй удирдлагын шийдвэрээр байгуулна.
- 2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах зөвлөлийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.
- 2.3. Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийг сумын Санхүүгийн албаны даргаар ахлуулж, сумын Засаг даргын орлогч дарга, төрийн сангийн мэргэжилтэн нарыг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын Засаг даргын захирамжаар байгуулна.

2.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд нь тусгаж ажиллах нөхцөл боломжоор хангана.

2.5. Сум болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөл нь ажлын төлөвлөгөөг боловсруулж, жил бүрийн 01 сарын 15-ны өдөрт багтаан сумын засаг дарга болон хуулийн этгээдийн удирдлагаар батлуулж ажиллана.

2.6. Сумын өмч хамгаалах зөвлөл жилд 1-ээс доошгүй сумын харъяа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллана.

2.7. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөлийн дарга хуралдааныг даргална. Даргын эзгүйд түүний даалгаснаар аль нэг гишүүн хуралдааныг даргална.

2.8. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хуралдаан ээжит болон ээлжит бус хэлбэртэй байна.

2.9. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ээлжит хуралдааныг хагас жил тутамд зохион байгуулна. Зөвлөлийн хуралдаанд олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно. Асуудлыг хуралд оролцсон олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.10. Ээлжит бус хуралдааныг зөвлөлийн даргын товлосноор буюу гишүүдийн гуравны нэг болон удирдлагын санал болгосноор зарлан хуралдуулна.

2.11. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн гишүүн асуудлыг хуралдаанд танилцуулна. Тухайн асуудлыг боловсруулсан албан хаагч нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зорилгоор хуралдаанд байлцана.

2.12. Хуралдаанд хууль тогтоомжид нийцсэн, зохих судалгаа, тооцоо, нотлох баримтад үндэслэсэн, санхүүгийн болон хөрөнгийн холбогдох журамд нийцүүлэн бэлтгэсэн асуудлыг хэлэлцэнэ.

2.13. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг тусгасан хуралдааныг дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

2.14. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг ажлын 3 өдөрт багтаан бичиж хуралдаан даргалагч, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

2.15. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд дараах зүйлийг тусгана.

2.15.1. хурал болсон огноо, эхэлсэн, завсарласан, дууссан цаг минут

2.15.2. хурал болсон газар

2.15.3. хурлын ирц, хуралд оролцоогүй гишүүдийн нэр, шалтгаан

2.15.4. хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан болон байлцсан этгээдийн нэр, албан тушаал

2.15.5. хэлэлцсэн асуудалтай холбогдуулан тавьсан асуулт, хариулт, санал дүгнэлт, танилцуулга, тайлбар, хурлаас гарсан шийдвэр

2.16. Өмч хамгаалах Байнгын зөвлөл санал боловсруулах, шийдвэр хэрэгжүүлэхдээ эрх бүхий байгууллагаас баталсан үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх, ашиглалтаас хасах, устгах баримт болон зохих бусад материалыг ашиглана.

2.17. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дарга жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, зөвлөлийн гишүүдийн ирц, чиг үүргийн биелэлтийг жилд 2-оос доошгүй удаа гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

2.18. Сум болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөл тухайн жилд гүйцэтгэсэн ажил, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан ажлын тайланг дараа жилийн ажлын төлөвлөгөөний хамт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан удирдлагад танилцуулан баталгаажуулж, 2 дугаар сарын 01-ний дотор Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

2.19. 5 хүртэл орон тоотой сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа өмчийн үр ашгийг дээшлүүлэх талаар тухайн сумын өмч хамгаалах зөвлөлд асуудлаа тавьж шийдвэрлүүлж болно.

Гурав. Өмч хамгаалах зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь орон нутгийн өмчийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих, түүний үр ашгийн дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

3.2. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, дараах байдлаар зөвлөмж, дүгнэлт гаргана.

3.2.1. хуулийн этгээдийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө олж авах бол эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, хөрөнгийн тоо хэмжээ, үнийн дээд хязгаар, техникийн болон бусад шаардлагын талаар зөвлөмж гаргана.

3.2.2. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон олж авсан хөрөнгө, төслийн шугамаар бий болсон эд хөрөнгийг бүртгэх бол хөрөнгийн чанар байдлыг нь харгалзан элэгдэл, хорогдлыг нь тооцон ашиглах хугацааг тогтоож дүгнэлт гаргана.

3.2.3. хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх бол хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй урьдчилан зөвшилцөж дүгнэлт гаргана.

3.2.4. хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдах бол хөрөнгийг худалдах доод үнийн санал бүхий дүгнэлт гаргана.

3.2.5. хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг акталж данснаас хасах бол үндэслэл, хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргана.

3.2.6. эд хөрөнгийн дотоодын тооллогын дүнгээр дутагдсан, маргаантай, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн шалтгааныг тогтоож дүгнэлт гаргана.

3.2.7. удирдлагад хуулиар олгосон бүрэн эрхээ хэрэгжүүлэх тухай асуудлыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж гаргана.

3.3. Сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөл нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах зэрэг эд хөрөнгийн зохицуулалт, үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа өмчийн үр ашгийг дээшлүүлэх талаар гаргасан зөвлөмж дүгнэлтийг холбогдох журмын дагуу сумын өмч хамгаалах зөвлөлд хүргүүлнэ.

3.4. Өмч хамгаалах зөвлөл нь үйл ажиллагаандаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан орон нутгийн өмчийн харилцааны журмыг удирдлага болгоно.

3.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах асуудлыг өмч хамгаалах зөвлөл судлан дүгнэлт гаргах бөгөөд хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар шийдвэрлэнэ. Өмч хамгаалах зөвлөл шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

3.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдаж, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөл, сумын харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд сумын өмч хамгаалах зөвлөл тус тус дор дурдсан шаардлагыг хангаж Орон нутгийн өмчийн газарт хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна:

3.6.1. төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд санал ирүүлэх

3.6.2. хуулийн этгээдийн эрх барих эсхүл харьяа дээд байгууллагад уламжилж санал авсан байх

3.6.3. аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан орон нутгийн өмчийн харилцааны журамд заасан материалын бүрдлийг бүрэн хангаж, хөрөнгийн жагсаалтыг үнэн зөв, баримт бичгийн стандартын шаардлага хангаж ирүүлэх

3.7. Өмч хамгаалах зөвлөл нь эрх бүхий байгууллагын эд хөрөнгийн зохицуулалтын шийдвэрийг гүйцэтгэх удирдлагын тушаалаар комисс томилон хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Орон нутгийн өмчийн газарт албан бичгээр хүргүүлэх үүрэг хүлээнэ.

3.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөл нь шийдвэрийн дагуу шилжүүлэх хөрөнгийг актаар хүлээлцэх, акталж данснаас хасах хөрөнгийг ангилж үнэ тогтоон хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах, сэлбэг, материал болгон ашиглах, устгах хөрөнгийг устгалын акт үйлдэн данснаас хасах ажлыг зохион байгуулна.

3.9. Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд тавих дотоодын хяналт, шалгалтыг дотоод хяналтын нэгжтэй хамтран зохион байгуулж, холбогдох санал дүгнэлтээ гүйцэтгэх удирдлага, түүнчлэн эрх бүхий дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

3.10. Өмч хамгаалах зөвлөл нь төрийн өмчийн харилцааг зохицуулах хууль тогтоомж, холбогдох бусад хууль, дүрэм журмыг мөрдөж ажиллахыг тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, холбогдох ажилтнаас шаардах, тайлбар гаргуулах эрхтэй.

3.11. Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөл нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах, түрээсийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалт, түрээсийн хөрөнгийн ашиглалт, чанар байдалд хяналт тавьж ажиллана.

3.12. Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана.

3.13. Хөрөнгө олж авах зардлын төлөвлөлт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулахад хяналт тавина.

3.14. Орон нутгийн өмчийг үрэгдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ авах, зөрчил гаргасан этгээдтэй хариуцлага тооцох асуудлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Бусад

4.1. Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон өмчийн харилцаатай холбоотой бусад хууль тогтоомж, эрх зүйн актад заасан хариуцлага хүлээнэ.

4.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах зөвлөлийн ажлын үр дүнгээс хамааруулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн урамшуулал олгоно.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 04

Мандалговь

Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний түрээсийн төлбөрийн хэмжээ нь батлагдсан жишиг үнээс багагүй байхаар хянан баталгаажуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-г үүрэг болгосугай.

Гурав. Түрээсийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, батлагдсан жишиг үнээс багагүй байхаар байгуулан Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-аар батлуулан ажиллахыг Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

Дөрөв. Энэхүү тогоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцож, “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ”-ийг 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА С. СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24-ны өдрийн 07 тогтоолын хавсралт

Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн
түрээсийн төлбөрийн жишиг үнэ

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь санхүүгийн тайлан балансад тусгагдсан орон нутгийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг өмчийн бусад хэлбэрийн хуулийн этгээд иргэнд түрээслүүлэх төлбөрийн хэмжээг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэлийг харгалзан дараах байдлаар тогтооно.

№	Түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбар, чиглэл, зориулалт	1 м.кв ашигтай талбайн түрээсийн төлбөрийн жишиг үнэ /төгрөг/	
1	Худалдаа, үйлчилгээ	5500	
2	Албан тасалгааны зориулалтаар	5000	
3	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	7500	
4	Тариалангийн талбай, хүлэмж	2000	
5	Орон сууц	Тухайн байгууллагын ажилтан болон төсвийн байгууллагын ажилтан	1500
		Бусад ¹	2500
6	Бусад	5000	

¹ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчлөлийн орон сууцыг эзэмшиж буй этгээд, түүний ажилладаг албан газартай гэрээ байгуулж төлбөр тооцоог хийлгэнэ/

2. Түрээсийн төлбөрийн жишиг үнийг дор дурдсан нөхцөлд дараах хувь хэмжээгээр бууруулан тогтоож болно:

2.1. Сумын төвд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон сууцнаас бусад түрээслүүлж буй байрны түрээсийн төлбөрийн жишиг үнийг 30 хувиар,

2.2. Орон нутгийн өмчийн бүртгэлд байгаа ашиглалтгүй барилга байгууламжийг түрээслэгчийн зардлаар засаж сэлбэн түрээслүүлэхэд /баримт нотолгоон дээр тулгуурлан/ түрээсийн төлбөрийн жишиг үнийг 20 хүртэл хувиар,

2.3. Барилгын туслах талбай /подвал, вестибюль гэх мэт/-г түрээслүүлэхэд төлбөрийн жишиг үнийг 20 хүртэл хувиар,

2.4. Төвлөрсөн системд холбогдоогүй орон сууцны барилгын төлбөрийн жишиг үнийг 20 хүртэл хувиар,

2.5. Спортын холбоо, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны чиглэлээр түрээсэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг 40 хүртэл хувиар,

3. Орон нутгийн өмчийн байранд байрлаж буй төсөвт байгууллага, албан газрын ашиглаж байгаа өрөө тасалгааны 1 м.кв ашигтай талбайн түрээсийн төлбөрийг төсөвт тусгасан зардлыг харгалзан тогтоож болно.

4. Орон нутгийн өмчийн байранд байрлаж буй орон нутгийн өмчит байгууллагын байрны түрээсийн төлбөрийг төсөвт тусгаагүй бол ашиглалтын зардлаар тооцон гэрээ байгуулж болно.

5. Орон нутгийн өмчийн хөдлөх эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн хэмжээг ашиглалт үйлчилгээнд зарцуулах зардал болон хөдлөх хөрөнгийн эдэлгээний норм, тухайн эд хөрөнгийн ашиглалтын хугацаа, элэгдэл хорогдлын шимтгэл, ашиглалтын нөхцөл, зах зээлийн дундаж үнэ зэргийг харгалзан түрээслүүлэгч өөрөө тогтоож, Орон нутгийн өмчийн газраар баталгаажуулна.

6. Орон нутгийн өөрийн өмчийн байр талбайд суурилуулсан зар, сурталчилгааны самбарын түрээсийн төлбөрийг зах зээлийн дундаж үнэд тулгуурлан түрээслүүлэгч, түрээслэгч нар харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

7. Технологийн болон үйл ажиллагааны үндсэн чиглэлээс бусад зориулалтаар байр талбайг бусдад эзэмшүүлж ашиглуулахад түрээсийн гэрээ байгуулж түрээсийн орлогоос 30 хувийг орон нутгийн орлогод төвлөрүүлж байна.

8. Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг тухайн салбарын онцлогоос шалтгаалан өөрчлөх шаардлага гарвал орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд Орон нутгийн өмчийн газарт уламжлан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж мөрдөж болно.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 08

Мандалговь

Түрээсийн гэрээний үлгэрчилсэн
загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлагдсантай холбогдуулан түрээслэгч, түрээслүүлэгчийн хооронд байгуулсан орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу баталгаажуулах, орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээсээр ашиглаж буй этгээдийн түрээсийн төлбөрийг болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг гэрээний нөхцөлөөр бүрэн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Орон нутгийн өмчийн газарын дарга (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 өдрийн *0.8* тогтоолын хавсралт

БАТЛАВ: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА С.УУГАНБАЯР

ОРОН НУТГИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

..... оны дугаар сарын-ны өдөр Дугаар сум

Энэхүү гэрээг нэг талаас орон нутгийн өөрийн өмчийн төлөөлөгч, Орон нутгийн өмчийн газар (цаашид "ОНӨГ" гэх), түүнийг төлөөлж тус газрын мэргэжилтэн, нөгөө талаас өмч эзэмшигч байгууллага (цаашид "түрээслүүлэгч" гэх), түүнийг төлөөлж тус байгууллагын (албан хаагчийн албан тушаал, нэр), нөгөө талаас (хуулийн этгээд, иргэний нэрийг бичих, цаашид "түрээслэгч" гэх) нар (цаашид хамтад нь "талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үндэслэн байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго: Түрээслүүлэгч орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгө (цаашид "түрээсэлсэн эд хөрөнгө" гэх)-ийг (түрээсийн зориулалтыг түрээсэлсэн эд хөрөнгө бүрээр заах) түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад хүлээлгэн өгөх, түрээслэгч нь уг гэрээнд дурдсан нөхцөлөөр түрээсийн төлбөр төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Түрээслүүлэгчийн эзэмшилд байгаа орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгө (түрээсэлсэн эд хөрөнгө, түүний дагалдах эд хөрөнгийн хаяг байршил, давхар, өрөөний дугаар, талбайн хэмжээ, тоо ширхэг, чанар болон бусад шаардлагатай үзүүлэлтийг тусгах) байна.

1.3. Түрээсийн гэрээний хугацаа: Орон нутгийн өмчийн газар энэхүү гэрээг албан ёсоор баталгаажуулсан өдрөөс эхлэн (... хүртэл жил) буюу хүртэл (дуусах огноог тусгах) байна.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

1.4.Түрээсийн гэрээг дүгнэх: Түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний үүргийн биелэлтийг хамтран дүгнэн 3 хувь акт үйлдэнэ.

1.5.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил газрыг түрээслүүлэх, ашиглуулах, эзэмшүүлэх болон түрээсэлсэн эд хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх харилцааг энэхүү түрээсийн гэрээгээр зохицуулахгүй болно.

Хоёр.Эд хөрөнгө түрээслүүлэх, хүлээлцэх

2.1.Түрээслүүлэгч нь цаашид ашиглах боломжтой орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлнэ.

2.2.Түрээслүүлэгч, түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийн өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан 3 хувь акт үйлдэж хүлээлцэнэ. Түрээсэлсэн эд хөрөнгө хүлээлцсэн акт нь энэхүү түрээсийн гэрээний 1 дүгээр хавсралт болно.

2.3.Түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээний 1.1-д заасан зориулалтын дагуу түрээсэлж, чанар байдлыг муутгахгүй (хэвийн элэгдэл хорогдлыг тооцохгүй)-гээр эзэмшиж ашиглах бөгөөд түрээсэлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

2.4.Түрээсэлсэн эд хөрөнгийг бусдад дамжуулан түрээслэх, барьцаалах, шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

2.5.Түрээслэгч нь түрээслүүлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр түрээсэлсэн эд хөрөнгөд зөвхөн Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрлөөр хөрөнгө оруулалт хийж болно. Түрээсэлсэн эд хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх асуудлыг тусад нь гэрээгээр зохицуулна.

2.6.Түрээслэгч нь түрээслүүлэгчтэй харилцан тохиролцсоны дагуу барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулахгүйгээр түрээсэлсэн эд хөрөнгийн өнгө үзэмжийг сайжруулах, нэмэгдүүлэх шаардлагаар өөрийн хөрөнгөөр урсгал засвар хийж болно. Энэ тохиолдолд түрээслүүлэгч нь засварын зардлыг хариуцахгүй, хөрөнгө оруулалтад тооцохгүй, түрээсийн төлбөрт суутгахгүй.

2.7.Түрээслүүлэгч, түрээслэгч нар түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалтын зардлыг хэмжигдэхүйц байлгах арга хэмжээ авна.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

Гурав. Төлбөр тооцоо, барьцаа

3.1.Энэхүү гэрээний 1.2-т заасан түрээсэлсэн эд хөрөнгийн 1 м.кв талбайн 1 (нэг) сарын түрээсийн төлбөр нь (тоо, үсгээр бичих) төгрөг, нийт төлбөр нь (тоо, үсгээр бичих) төгрөг болно.

3.2.Түрээсийн төлбөр нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар тогтоосон жишиг үнэтэй уялдсан байна.

3.3.Түрээслэгчийн гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож 1 (нэг) сарын түрээсийн төлбөртэй тэнцэх хэмжээний буюу (тоо, үсгээр бичих) төгрөгийг барьцаа болгон энэхүү гэрээний хугацаанд хадгална.

Барьцаа байршуулах банкны нэр:

Дансны дугаар:

Мөнгөн дүн /төгрөг/:

3.4.Түрээслэгч нь түрээсийн сарын төлбөр болох(тоо, үсгээр бичих) төгрөгийг тухайн сарын 25-ны өдрийн дотор түрээслүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

Түрээсийн төлбөр төлөх:

Дансны дугаар:

Мөнгөн дүн:

3.5.Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 30 хувь болох (тоо, үсгээр бичих) төгрөгийг сар тутам орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны дараа сарын 10-ны дотор Орон нутгийн өмчийн газарт өгнө.

Түрээсийн орлого төвлөрүүлэх: Банкны нэр:

Дансны дугаар:

Мөнгөн дүн:

3.6.Түрээсийн төлбөр нь түрээсэлсэн эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашигласны төлөө түрээслэгчээс төлж буй төлбөр болно. Түрээсийн төлбөрт түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалт (цахилгаан, дулаан, уур, цэвэр, бохир ус, интернэт, телефон утас, кабелийн суваг, хог хаягдал, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, бусад)-ын зардал багтаагүй болно.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

3.7.Түрээслэгч нь энэхүү гэрээнд заасан ашиглалтын зардлыг ханган нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу тогтоосон хугацаанд, бүрэн хэмжээгээр, зохих дансанд төлж барагдуулна.

3.8.Түрээсийн барьцаа нь гэрээний дагуу төлөх түрээсийн төлбөр, ашиглалтын зардалд хамаарахгүй болно.

3.9.Энэхүү гэрээний 1.4-т заасан гэрээ дүгнэсэн актад барьцаа хөрөнгийг түрээслэгчид шилжүүлэх эсэх талаарх үндэслэл, нөхцөлийг тодорхой заах бөгөөд түрээслүүлэгч, түрээслэгч нь барьцаа хөрөнгийг шилжүүлэхээр тохиролцсон бол барьцаа хөрөнгийн хэмжээ, хугацааг нэмж тусгана.

Дөрөв. Орон нутгийн өмчийн газрын эрх, үүрэг

4.1.Түрээсийн гэрээг хянан батлах, гэрээг нэг талын санаачилгаар, гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцлах эрхтэй.

4.2.Түрээсэлсэн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, түрээсийн төлбөр төлөлт, түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.

4.3.Түрээслүүлэгч түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 30 хувийг Төрийн сан банкинд энэхүү гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

4.4.Түрээсэлсэн эд хөрөнгөд зохих журмын дагуу хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгох, холбогдох гэрээг байгуулах, түүнд хяналт тавих эрхтэй.

4.5.Энэхүү гэрээний 5.7-д заасан саналыг судлан үзэж, 30 хоногт багтаан хариу өгөх үүрэгтэй.

4.6.Барилгын бүтээц, хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүй өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн тохиолдолд барилгыг хэвийн байдалд нь оруулах, учирсан хохирлыг арилгахыг түрээслэгчээс шаардах эрхтэй.

4.7.Түрээслүүлэгч, түрээслэгчээс гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих эрхтэй.

4.8.Түрээслэгчээс бусдад учруулсан хохирлыг хариуцах үүрэг хүлээхгүй.

4.9.Түрээслэгчийн энэхүү гэрээний 2.6-д заасны дагуу хийсэн засварын зардлыг хариуцах үүрэг хүлээхгүй.

4.10.Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

Тав. Түрээслүүлэгчийн эрх, үүрэг

5.1.Түрээслэгчид түрээсэлсэн эд хөрөнгийг нэг бүрчлэн хүлээлгэн өгч, энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу актад бүрэн тусгах үүрэгтэй.

5.2.Түрээслэгчийг хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах үүрэгтэй.

5.3. Түрээслүүлэгч нь түрээсээр эзэмшүүлж буй орон нутгийн өмчийн бүрэн бүтэн байдлыг аймгийн ИТХ-ын өмнө шууд хариуцна.

5.4.Түрээслэгч эд хөрөнгийн эзэмшил ашиглалт, хамгаалалтыг хариуцах, түрээсийн төлбөр, ашиглалтын зардал төлөх болон гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах эрхтэй.

5.5.Түрээслэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

5.6.Түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд түрээсийн гэрээг цуцлах саналаа Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх үүрэгтэй.

5.7.Түрээслэгчээс түрээсэлсэн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар тавьсан барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулахаас бусад саналыг судлан үзэж, ажлын 3 өдрийн дотор хариу өгөх үүрэгтэй.

5.8.Түрээслэгчийн барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтөд өөрчлөлт оруулах саналыг хүлээн аваад ажлын 3 өдрийн дотор Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх үүрэгтэй.

5.9.Түрээсэлсэн эд хөрөнгөд түрээслэгчээс үл хамаарах шалтгаанаар осол, гэмтэл гарвал түүний үр дагаврыг арилгах арга хэмжээг яаралтай авах үүрэгтэй.

5.10.Түрээсэлсэн эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх, хувьчлах шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай түрээслэгчид ажлын 5 өдрийн дотор албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй. Шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоног өнгөрсний дараа түрээсийн гэрээг нэг талын санаачилгаар цуцалж болно.

5.11.Түрээсийн төлбөрийн зохих хувийг энэхүү гэрээнд заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

5.12.Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй бол энэхүү гэрээнд заасан алданги ногдуулж, төлүүлэх эрхтэй.

5.13.Түрээслэгчийн энэхүү гэрээний 2.6-д заасны дагуу хийсэн засварын зардлыг хариуцах үүрэг хүлээхгүй.

5.14.Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Зургаа. Түрээслэгчийн эрх, үүрэг

6.1.Түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй.

6.2.Түрээсэлсэн эд хөрөнгийг энэхүү гэрээний 2.2-т заасны дагуу актаар хүлээн авах үүрэгтэй.

6.3.Түрээсэлсэн эд хөрөнгөд урсгал засварыг өөрийн зардлаар хийх үүрэгтэй. Урсгал засвар гэдэгт барилгын их засвар хооронд барилга ашиглалтыг сайжруулахаар хийгдэж буй засварыг ойлгоно.

6.4.Түрээсэлсэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй.

6.5.Түрээслэгчийн буруутай үйл ажиллагаанаас түрээсэлсэн эд хөрөнгөд учирсан гэмтэл, эвдрэл, хохирлыг бүрэн хариуцаж, өөрийн хөрөнгөөр барагдуулах үүрэгтэй.

6.6.Түрээсэлсэн эд хөрөнгөд Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүйгээр анхны зураг төслийн шийдлийг өөрчлөх, хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

6.7.Энэхүү гэрээнд заасны дагуу зохих зөвшөөрөл аваагүй хийсэн хөрөнгө оруулалт, засварын зардлыг гэрээ хэрэгжих хугацаанд болон гэрээ цуцалсны дараа буцаан авах болон шаардах эрхээ алдана.

6.8.Түрээсийн төлбөр болон ашиглалтын зардлыг энэхүү гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.

6.9.Түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээслэх, барьцаалах, бусдад шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

6.10.Түрээсийн хугацаа дуусгавар болоход өөрийн хөрөнгөөр авсан эд хогшил, тоног төхөөрөмжийг түрээслүүлэгчийн байр, эд хөрөнгийг сэвтээхгүй, гэмтээхгүй нөхцөлд салган авч болно.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

6.11.Түрээсийн хугацаа дуусгавар болоход түрээсэлсэн эд хөрөнгийг түүнээс салгаж үл болох хөрөнгө оруулалт, засварын хамт түрээслүүлэгчид актаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.12.Түрээсэлсэн эд хөрөнгөд хийсэн урсгал засвар, үйлчилгээний тайланг түрээслүүлэгчид тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй.

6.13.Түрээсийн хугацаа дуусахаас өмнө гэрээг түрээслэгчийн санаачилгаар цуцалсан нөхцөлд барьцаа болон түрээсийн төлбөрийг шаардах эрхээ алдана.

6.14.Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Долоо. Талуудын хариуцлага

7.1.Энэ гэрээнд заасан нөхцөлийг зөрчсөн тал түүнээс болж нөгөө талд, бусдад учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргалдах журмаар төлнө.

7.2Талууд гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал нь үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

7.3.Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй-үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

7.4.Түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээсэлсэн, бусдад барьцаалсан, шилжүүлсэн, баталгаа гаргасан бол барьцаа нэхэмжлэх эрхээ алдана.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1.Гэрээг тайлбарлах болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

8.2.Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

9.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийнэргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

9.2.Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

9.3.Шаардлагатай бол эрх бүхий байгууллагаас гаргасан нотлох баримт нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл байсан, мөн түүний үргэлжилсэн хугацааны нотолгоо болно.

Арав. Гэрээг цуцлах болон нэмэлт, өөрчлөлт оруулах

10.1.Орон нутгийн өмчийн газраас түрээсийн гэрээг дараах тохиолдолд нэг талын санаачилгаар, түрээсийн гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцалж болно:

10.1.1.Түрээслэгч барилгын үндсэн бүтээц, хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, эвдэлсэн, гэмтээсэн;

10.1.2.Түрээслэгч түрээсэлсэн эд хөрөнгийг дамжуулан түрээсэлсэн, бусдад барьцаалсан, шилжүүлсэн, баталгаа гаргасан, дутагдуулсан, шамшигдуулсан;

10.1.3.Төрийн эрх бүхий байгууллагаас түрээсэлсэн эд хөрөнгийг шилжүүлэх, худалдах, хувьчлахаар шийдвэрлэсэн;

10.1.4.Түрээслэгч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон;

10.1.5.Түрээсэлсэн эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашиглаагүй, түрээслүүлэгчийн тавьсан шаардлагыг үндэслэлгүйгээр 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй;

10.1.6.Түрээсийн төлбөрийг 30 хоногоор хугацаа хожимдуулан төлсөн.

10.2.Түрээслэгчийн санаачилгаар түрээсийн гэрээг хугацаа дуусахаас өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд түрээсийн барьцаа, түрээсийн төлбөрийг түрээслэгчид олгохгүй болно.

10.3.Түрээслэгч энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах саналаа түрээслүүлэгчид 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

10.4.Гэрээг цуцлах саналаа нөгөө талдаа заавал бичгээр мэдэгдэнэ.

10.5.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулна.

10.6.Энэхүү гэрээний нэмэлт, өөрчлөлт нь тус гэрээний салшгүй хэсэг байна.

ОНӨГ-ыг төлөөлж:

Түрээслүүлэгчийг төлөөлж:

Түрээслэгч

()

()

()

10.7. Гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг санаачилсан тал нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Нөгөө тал нь саналыг зөвшөөрсөн эсэх тухай хариуг ажлын 10 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

10.8. Түрээсийн гэрээг дуусахаас өмнө 30 хоногт багтаан гэрээг сунгах эсэх талаар түрээслэгчид саналаа илэрхийлж сунгуулна. Саналаа ирүүлээгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссанд тооцно.

Арван нэг. Бусад

11.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

11.2. Гэрээ нь холбогдох бичиг баримтын хамт нийт () хуудас бөгөөд Монгол хэл дээр 3 (гурав) хувь үйлдэж, тал тус бүр 1 (нэг) хувийг хадгална. Гэрээний эх хувь нь хууль зүйн адил хүчинтэй байна.

11.3. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

11.4. Бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

11.5. Талууд гэрээний биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн нөхцөлд түрээсийн гэрээг мөн нөхцөлөөр 1 (нэг) жилээс илүүгүй хугацаагаар хоёр удаа сунгаж болно.

11.6. Энэхүү түрээсийн гэрээнд түрээслэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний цахим үнэмлэх, холбогдох тусгай зөвшөөрөл, бусад шаардлагатай баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбарыг тус тус хавсаргана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Орон нутгийн өмчийн газрыг төлөөлж:	Түрээслүүлэгчийг төлөөлж	Түрээслэгч:
Орон нутгийн өмчийн газрын, мэргэжилтэн нэр, Утас: 70592488 Мэйл хаяг:	(байгууллага, албан хаагчийн нэр) Утас: Мэйл хаяг:	(байгууллага/иргэн/-ын гарын үсэг) Утас: Мэйл хаяг:
ОНӨГазрыг төлөөлж: (нэр, гарын үсэг)	Түрээслүүлэгчийг төлөөлж: (нэр, гарын үсэг)	Түрээслэгч: (нэр, гарын үсэг)

Түрээсийн гэрээний 1 дүгээр
хавсралт

ТҮРЭЭСЭЛСЭН ЭД ХӨРӨНГӨ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

20.... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Д/д	Түрээсэлсэн эд хөрөнгийн	Тоо, талбайн хэмжээ	Ашиглал- тад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Өнгө үзэмж	Чанар байда л	Зориу- лалт	Тайл- бар
1								
2								
3								
4								
5								
6								
7								

Энэхүү актад түрээсэлсэн эд хөрөнгө бүрийн 4 талаас авсан өнгөт фото зургийг хавсаргана.

Эд хөрөнгө хүлээлгэн өгсөн
түрээслүүлэгч:

.....

(байгууллага, албан хаагчийн
нэр, гарын үсэг)

Эд хөрөнгө хүлээн авсан
түрээслэгч:

.....

(байгууллага, албан хаагч
/иргэн/-ийн нэр, гарын үсэг)

ОНӨГ-ыг төлөөлж:

.....

(нэр, гарын үсэг)

Түрээслүүлэгчийг төлөөлж:

.....

(нэр, гарын үсэг)

Түрээслэгч:

.....

(нэр, гарын үсэг)

Түрээсийн гэрээний 2 дугаар хавсралт

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

20.... оны.....дугаар сарын-ны өдөр

Д/д	Түрээсэлсэн эд хөрөнгийн	Тоо, талбайн хэмжээ	Нэг сарын түрээсийн төлбөрийн	Түрээсийн төлбөр төлөх	Төлсөн дүн (төгрөг)	Биелэлт
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
Нийт дүн						
Орон нутгат						

Түрээслүүлэгчийг төлөөлж:

.....

.....

(байгууллага, албан хаагчийн нэр,

иргэн/-

гарын үсэг)

ОНӨГ-ыг төлөөлж:

.....

(нэр, гарын үсэг)

Түрээслэгчийг төлөөлж:

.....

.....

(байгууллага, албан хаагч /эсхүл

ийн нэр, гарын үсэг)

Түрээслэгч:

.....

(нэр, гарын үсэг)



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 09

Мандагговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх, акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 910,411,625 /есөн зуун арван сая дөрвөн зуун арван нэгэн мянга зургаан зуун хорин таван/ төгрөгийн балансын үнэтэй, 861,356,591 /найман зуун жаран нэгэн сая гурван зуун тавин зургаан мянга таван зуун ерөн нэг/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй ахуй үйлчилгээний зориулалтай блокон барилга болон Соёл спортын цогцолборын барилгыг газрын хамт сумын Соёлын төвийн балансад нэгдүгээр хавсралтаар, Засаг даргын Тамгын газрын тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 38,792,050 /гучин найман сая долоо зуун ерэн хоёр мянга тавин / төгрөгний балансын үнэтэй, 12,930,683.44/арван хоёр сая есөн зуун гучин мянга зургаан зуун наян гурав/ төгрөгийн өртөгтэй 69-16 ДУА улсын дугаартай УАЗПатриот авто машиныг Дундговь аймгийн Цагдаагийн газрын балансад хоёрдугаар хавсралтаар тус тус шилжүүлж, Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 107,829,504 /Нэг зуун долоон сая найман зуун хорин есөн мянга таван зуун дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй 85,926,917 /наян таван сая есөн зуун хорин зургаан мянга есөн зуун арван долоон/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг гуравдугаар хавсралтын дагуу акталж данснаас хасахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр. Гурвансайхан сумын Засаг дарга Л.Өлзийбат, аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.

2.1 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.2 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 29 тогтоолын нэгдүгээр хавсралт


Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн	Хуриглагдсан элэгдэл	Үлдэх өргөг
1	Барилга блок-ахуйн үйлчилгээний барилга	1992-01-01	M2	51,383,700.80	51,383,700.80	3,623,209.70	47,760,491.10
2	SSS-догцолборын барилга	2018-06-30	M2	859,027,925.02	859,027,925.02	45,431,824.20	813,596,100.82
Нийт дүн					910,411,625.82	49,055,033.90	861,356,591.92
					/есөн зуун арван сая дөрвөн зуун арван нэгэн мянга зургаан зуун хорин тав/ төгрөг	/дөчин есөн сая тавин таван мянга гучин гурав/	/ найман зуун жаран нэгэн сая гурван зуун тавин зургаан мянга таван зуун ерөн нэг/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 28 тогтоолын хоёрдугаар хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд орсон огноо	Тээврийн хэрэгсэл			Нийт гүйлт	Блансын үнэ	Үлдэгдэл өрөг
		Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн			
1	УАЗ патриот	ДУА	69-16	2015	2015.11.16	316300F0523369	-	2693	82.802	38.792.050	12.930.683.44
	Нийт дүн									38.792.050 / Гучин найман сая долоон зуун ерэн хоёр мянга тавь/ төгрөг	12.930.683.44 /арван хоёр сая есөн зуун гучин мянга зургаан зуун наян гурав/төгрөг


 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
 24 ны өдрийн 09 тогтоолын гуравдугаар хавсралт

Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын
 данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Тоо хэмж ээ	2018.12.31-нд дахин үнэлсэн өртөг	Хурилтлагдс ан элэгдэл	Үлдэх өртөг
1	Мэдээллийн төв, нийтийн ахуйн үйлчигээний чулуун барилга	1960-01-01	м2	12,373,793.52	1,620,377.77	10,753,415.75
2	Тэжээл, бордооны агуулах	1970-01-01	м2	36,766,860.63	4,212,857.99	32,554,002.64
3	Гурвансайхан багийн контор	1963-01-01	м2	2,258,496.00	295,755.46	1,962,740.54
4	Дэрсэнэ ус багын контор	1963-01-01	м2	7,931,550.00	7,391,763.77	539,786.23
5	Чулуут багийн контор	1963-01-01	м2	5,882,250.00	5,841,930.02	400,319.98
6	Элгэн багийн контор	1963-01-01	м2	2,446,704	320,401.73	2,126,302.27
7	Дулааны шугам	2015-12-24	м	33,392,800.00	666,373.40	32,726,426.60
8	Цэвэр усны шугам	2015-12-24	м	6,777,050.00	1,913,126.60	4,863,923.40
Нийт дүн				107,829,504.15 /зуун долоон сая найман зуун хорин есөн мянга таван зуун дөрвөн/төгрөг	21,902,586.74 /хорин нэгэн сая есөн зуун хоёр мянга таван зуун наян зургаа/төгрөг	85,926,917.41 / Наян таван сая есөн зуун хорин зургаан мянга есөн зуун арван долоо/ төгрөг



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 10

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 12,374,663 / арван хоёр сая гурван зуун далан дөрвөн мянга зургаан зуун жаран гурав/ төгрөгийн балансын үнэтэй 4,035,258/ дөрвөн сая гучин таван мянга хоёр зуун тавин найм/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 19 нэр төрлийн хавсралтанд заасан эд хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж устган, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Нийтлэг үйлчилгээ үйлвэрийн газрын дарга (Ё.Дашням)-т даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 10 тогтоолын хавсралт

Дундговь аймгийн нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газрын
данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашигла лтад орсон огноо	Тоо хэм жээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлаг дсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Төмс шарагч	14.05.02	1	143,000	143,000.00	143,000.00	-
2	Сэтгүүлийн ширээ	14.5.02	2	72,360	144,720.00	144,720.00	-
3	Билардын ширээ	14.05.2	1	4,522,500	4,522,500	4,522,500	
4	хоолны ширээ	14.05.02	3	16,281	48,843.00	48,843.00	-
5	сейф	87.12.30	2	90,450	180,900.00	180,900.00	-
6	ширээ эвхдэг	14.05.02	8	52,000	416,000	284,266.67	131,733.33
7	ширээ эвхдэг том	14.05.02	2	100,000	200,000	136,666.67	63,333.33
8	Дугуй ширээ	14.12.31	1	295,000	295,000	201,583.33	93,416.67
9	гэр модон сандал	17.11.15	2	20,000	40,000	8,000	32,000
10	Буудал ширээ сандал	17.12.31	6	400,000	2,400,000	480,000	1,920,000
11	хөшиг	17.12.31	7	230,000	1,610,000	644,000	966,000
12	Гадуур цагаан бүрээс	18.06.30	5	90,000	450,000	120,000	330,000
13	Усан оргилуур	18.06.30	1	324,000	324,000	86,400	237,600
14	будаа агшаагч	16.12.31	1	77,000	77,000	46,200	30,800
15	гагнуурын аппрад	04.12.30	1	97,800	97,800	97,800	-
16	мини хөргөгч	17.12.31	1	285,000	285,000	54,625	230,375
17	телевиз	14.05.02	2				

				268,950	537,900	537,900	-
18	компьютер	10.03.29	1	470,000	470,000	470,000	-
19	Ус буцалгагч	14.05.02	1	132,000	132,000	132,000	-
20	Нийт дүн			7,686,341 /Долоон сая зургаан зуун наян зургаан мянга гурван зуун дөчин нэг/	12,374,663 /арван хоёр сая гурваг зуун далан дөрвөн мянга зургаан зуун жаран гурав/	8,339,404.67 /найман сая гурван зуун гучин ес дөрвөн зуун дөрөв/ төгрөг	4,035,258.33 /Дөрвөн сая гучин таван мянга хоёр зуун тавин найм/ төгрөг



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 11

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Луус сумын Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай 29,900,000 /хорин есөн сая есөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй Grand starex маркын автомашиныг үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Н.Долгоржав)-т дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1 Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах.

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай

ДАРГА  С.СҮХБААТАР





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 12

Мандалговь

Хөрөнгө бүртгэж авах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газарт шаардлагатай нийт 7,445,00.00 /долоон сая дөрвөн зуун дөчин таван мянга/ төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу бэлтгэж бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Эрдэнэцэцэг)-г дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ) -д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 12 тогтоолын хавсралт

Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэж
авах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Улсын төсвийн хөрөнгөөр				
1	Явган хүний зам	20 м ²	60,750.00.00	1,215,000.00
2	Авто зогсоол	125 м ²	14,080.00	1,760,000.00
3	Үүдний таамбар	1	4,470,000.00	4,470,000.00
	Нийт дүн		4,544,830.00 /дөрвөн сая таван зуун дөчин дөрвөн мянга найман зуун гуч/	7,445,000.00 /долоон сая дөрвөн зуун дөчин таван мянга/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 13

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 340,790,745 /гурван зуун дөчин сая долоон зуун ерэн мянга долоон зуун дөчин таван /төгрөгийн балансын үнэтэй, 204,474,447 / хоёр зуун дөрвөн сая дөрвөн зуун далан дарван мянга дөрвөн зуун дөчин долоон / төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 107,917,068 /нэг зуун долоон сая есөн зуун арван долоон мянга жаран найман / төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 62 ширхэг теле хяналтын камер, 4 ширхэг 52 inch led дэлгэц бүхий үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу Дундговь аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр. Дундговь аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (О.Амарсанаа), “Хот тохижуулах” газрын дарга (Х.Анхбаяр) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 22. тогтоолын хавсралт

Хот тохижуулах газрын балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д Орсон огноо	Хэмж их нэгж	Тоо хэм жээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Теле хяналтын систем иж бүрдэл	12/30/2015	ш	1	340,790,745	204,474,447	107,917,068
	Нийт дүн				340,790,745 /гурван зуун дөчин сая долоон зуун ерөн мянга долоон зуун дөчин тав / төгрөг	204,474,447 /хоёр зуун дөрвөн сая дөрвөн зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун дөчин долоо / төгрөг	107,917,068 /нэг зуун долоон сая есөн зуун арван долоон сая жаран найман / төгрөг



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 111

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэгийн орчмын бүртгэлгүй 2,795,164 /Хоёр сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун жаран дөрөв / төгрөгний цэвэр усны шугамыг “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дансанд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Гуравдугаар цэцэрлэгийн эрхлэгч Г.Мөнхтуяа, “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

- 2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллага болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах,
- 2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх
- 2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1-р сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 14 тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын Гуравдугаар цэцэрлэг
данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Тоо хэмж ээ	Нийт дүн	Хурилтлагд сан элэгдэл	Үлдэх өртөг
1	Цэвэр усны шугам ф50	2019-01-01	м	2,795,164.96	0	2,795,164.96
Нийт дүн				2,795,164.96 / Хоёр сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун жаран дөрөв ерөн зургаан мөнгө/		2,795,164.96 / Хоёр сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун жаран дөрөв ерөн зургаан мөнгө/



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 15

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг 6.2.1, 6.4 дэх заалтыг 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 669.662 /зургаан зуун жаран есөн мянга зургаан зуун жаран хоёр/ төгрөгийн балансын үнэтэй 46,093 /дөчин зургаан мянга ерөн гурван/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй эд хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж устган данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



ДАРГА - С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын
24 ны өдрийн 15 тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчийн газрын
данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Тоо хэм жээ	Нэгжийн үнэ	Нийт дүн	Хурилтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Принтер samsung 1660	2018-12-31	1	65,000.00	65,000.00	65,000.00	0.00
2	Компьютер	2016-09-01	2	34,711.10	69,422.20	69,422.20	0.00
3	Дүрс бичигч	2016-09-01	1	110,833.40	110,833.40	110,833.40	0.00
4	Халаагч тень	2016-09-01	1	108,333.33	108,333.33	108,333.33	0.00
5	Ус буцалгагч шүүгч	9/1/2016	1	316,073.40	316,073.40	269,979.60	46,093.80
Нийт дүн					669,662.33 /зургаан зуун жаран есөн мянга зургаан зуун жаран хоёр гучин гурван мөнгө/	353,588.93 /гурван зуун тавин гурван мянга таван зуун наян найм ерөн гурван мөнгө/	46,093.80 / дөчин зургаан мянга ерөн гурван төгрөг наян мөнгө/